

まんがでわかる



Монгол хэл

モンゴル語版

# 製造業3分野の安全衛生


※ここでの製造業3分野とは、素形材産業、産業機械製造業、電気・電子情報関連産業のこと。

## Зурагт номоор ойлгох аж үйлдвэрийн 3-н салбарын эрүүл ахуй, аюулгүй байдал.


Аж үйлдвэрийн 3-н салбар гэдэг нь материалын хэлбэрийн үйлдвэрлэл, аж үйлдвэрийн машин механизмын үйлдвэрлэл, цахилгаан тоног төхөөрөмжийн салбартай холбоотой үйлдвэрлэлийн тухай юм.







Өнөөдөр үйлдвэр дээрх эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар сурцгаая.




Хүнд материал болон машин механизмыг зөөвөрлөхдөө аюулгүй байдлаа анхаарцгаая.

Тийм шүү



Гарын ур дүйтэй хүмүүс ажиллаж байгаа гэж төсөөлөгдөж байна.


Ямар ажил гэдэг нь сонирхол татаж байна шүү.



Эхлээд ажилтай холбоотой осол аваарын тухай үзье!

Заааа!

Осол аваар гаргасан шалтгаан нь дараах байдалтай байна.



**Заааа! Үйлдвэрлэлийн 3-н салбарт гардаг үхэх аюултай ослыг хувиар нь авч үзвэл:**

1	Хавчуулагдах / Орооцолдох	32 %
2	Өндрөөс ойчих / Унах	13 %
3	Өнхөрч унах	12 %
4	Нисэх / Юмнаас унах	10 %
5	Болгоомжгүй үйлдэл / Хүчлэх	8 %
6	Зүсэх / Үрэх, нухах	8 %

Эрүүл мэнд, Хөдөлмөр, халамжийн яамны "Ажилчдын гэмтэл, бэртэл ослын байдлын талаар мэдээлсэн" (2009-2018 он) гаргасан мэдээллээр материал хэлбэрийн үйлдвэрлэл, аж үйлдвэрийн машин механизмын үйлдвэрлэл, цахилгаан / цахим мэдээлэлтэй холбоотой аж үйлдвэрийн нийт үнэлгээнд үндэслэн гаргасан болно.



"Хавчуулагдах/орооцолдох" осол нь бүх ослын 1/3-г эзлэж байна.












Жишээ нь: хамгаалах хэрэгсэлийг хэрэглэхгүй бол төмөр боловсруулах техникд хүрэхэд л гэмтэл авах,





гагнуурын ажил хийж байх үед үртэс залигах, арьс болон нүдээ гэмтээх аюултай юм.

Аюул хажууханд байх нь ээ.




Тийм учраас л хамгаалах хэрэгсэл маш чухал.

Хамгаалах хэрэгсэл нь аж үйлдвэр болон ямар ажил хийхээс шалтгаалан төрөл нь өөр өөр байдаг.





Яг өмсөх ёстой цагт нь өмсөх ёстой газарт нь зөв өмсөж хэрэглэхгүй бол ямар ч хэрэггүй.

Гэмтэлтэй техник төхөөрөмж болон хэрэгсэлийг үргэлжлүүлэн хэрэглэвэл аюултай биз дээ?




Тийм шүү

Энэ нэг л биш байна даа гэж бодвол шууд хариуцсан хүндээ хэлээрэй.




Ойлголоо.

За тэгвэл



Бодит байдлыг



カチツ...

харцгаая!



1



# Тохиолдол 1

## Өрөмдлөгийн машинд орооцолдох осол







энэ бээлий их эвтэйхэн юм.

жаахан том ч гэсэн нимгэн юм.

Нарийн төвөгтэй ажилд ч гэсэн санаа зоволтгүй хэрэглэж болох юм шиг байна.



Ашгүй, маргааш өрөмдлөгийн машин дээр ажиллахдаа өмсөж үзнэ ээ!

Ажлын өдөр



Яалт ч үгүй бээлий их тохиромжтой юм аа.




Жаахан том байгаа ч гэсэн анхааралтай байвал санаа зоволтгүй юм байна.



Хөөе!



Айн! Яасан бэ?



Яана аа! баларлаа!



Яана аааааа!





Аюултай байлаа шүү.



OFF!

on

Юугаа хийгээд байгаан бэ?



Эргээд хартал бээлий орооцолчихлоо.


Бээлий орооцолдох аюултай болохоор хориглодог юм!

Уучилаарай.

## Тоног төхөөрөмж ашиглах санамж

1

Бээлий орооцолдох аюултай болохоор хориотой!




Эргэлддэг төхөөрөмж ашигладаг ажилд бээлий нь татагдах, орооцолдох аюултай тул хэрэглэхгүй байхыг хүсье.



Бээлий NG / NG-болохгүй/

2


Техник төхөөрөмжнөөс холдож явахаар бол унтраагаарай.



OFF

on

OFF



Техник төхөөрөмжнөөс холдож явах, амрахаар явах үедээ цахилгаанаас салгаарай.



Эргэлдэх тоног төхөөрөмжтэй ажиллахдаа анхаарал болгоомжтой байцгаая!





Тохиолдол 2

Төмөр боловсруулахтай холбоотой осол







ёо  
ёооо

Яана аа,  
зүгээр үү?



Болохгүй ээ!

Жижиг осол байсан ч  
заавал хэлэхгүй бол  
болохгүй!

Ээ л дээ.





Одоо яах билээ,  
ганцхан байсан ном  
бүүр салбархай  
болчихлоо!

Гадны биет орсон тул  
зүсэлтийн хэмжээ  
алдагдлаа!



Гуйж байна.  
Би зүгээр болохоор  
энэ тухай хэнд ч  
битгий хэлээрэй.

Хянагч мэдчихвэл  
аймар загнуулах  
байх.



Миний  
анхааралгүйгээс  
болоод... Үнэхээр  
уучилаарай.







Их гэмтээгүй нь яамай даа.

айн?



Тайлбар ном болон бүтээгдэхүүнийг дахиад янзлахад л болно.

Чиний бие чинь илүү чухал шүү дээ.



Чамайг гэмтчихвэл

хамтран ажиллагсад болон гэр бүлийнхний чинь санаа зовно ш дээ.



Чамд ч гэсэн хэцүү биз дээ!



Уучилаарай.



За тэгэхээр, сайн санаж яваарай!


# Төмөр боловсруулах үеийн санамж

## 1 Алдаа гарсан даруйд нь мэдэгдэнэ үү



Төхөөрөмжинд алдаа гарсан үед шууд хариуцаж байгаа хянагчидаа мэдэгдээрэй.

## 2 Аюудгүй байдал №1







Бүтээгдэхүүн болон бусад эд зүйлсээс илүү өөрийн болон хамтран ажиллагсадынхаа аюулгүй байдал, эрүүл мэндээ анхаараарай.

Ажиллаж байгаа тоног төхөөрөмжинд гараа хийж болохгүй.











Тохиолдол 3  
Үйлдвэрийн дотор унах осол







Өө, ачааны машин хаалга таглаад тавьчихсан байх юм.






Хэд хоногийн  
дараа



## Үйлдвэр доторх санамж

**1** | Үйлдвэр дотор гүйхгүй, эргэн тойрноо сайн анхаарч байх.




Үйлдвэр болон агуулах дотор гүйхгүй, түр зогсон баруун зүүн талаа, эргэн тойрноо сайн харж, шалгаж байх.

**2** | Дүрмийн дагуу зөвшөөрөгдсөн гутлыг өмсөх!



хальтрах ултай гутал болон улавч, өсгийтэй гутал зэргийг өмсөхгүй байх.

**3** | Хөл доорхоо сайн харж унахаас болгоомжилно уу!






Шалан дээр асгарсан, унагасан болон залгуур, ачигч машины сэрээнээс болгоомжилно уу.

Унаж ойчихгүйн тулд анхаарал болгоомжтой байна уу.





Тохиолдол 4  
Өнгөлөгч төхөөрөмжтэй ажиллах үеийн осол



Уучилаарай,  
унтчихаж



Хоцорлоо!

Ажил чинь  
овоорчихлоо!



Өнөөдрийн өнгөлгөөний  
ажил бидний хийх ажил

Хоцорсоноос чинь болж  
дараагийн үйлдвэрийн  
явцад саад гарч байна.

Уучилаарай.








Хурдан хувцасаа  
сольчихоод ир!



3а











## Хэрэгсэлийг ашиглах анхааруулга

1

Ажлын хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэлээ дүрмийн дагуу зөв өмсөцгөөе.



Ажлын хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэл (хамгаалах нүдний шил, амны хаалт) зэргийг дүрмийн дагуу зөв өмсөх.

2


Эргэн тойронд аюултай зүйл байгаа эсхийг шалгацгаая.



Эргэн тойронд органик уусгагч болон шатамхай бодис байгаа эсхийг шалгаарай.

3

Төхөөрөмжийг унтраалгүй орхихоос болгоомжилно уу!



Өнгөлөгч зэрэг эргэлдэгч төхөөрөмжний цахилгааныг салгасаны дараа хөдөлгөөнгүй болтол нь хүлээж байгаад тавиарай.


Өнгөлөгчийг хэрэглэхдээ анхааралтай байна уу!





Тохиолдол 5

Багажыг зөв хэрэглээгүйгээс гарах осол










Яана аа,  
гэмтэл нь зүгээр  
болов уу?

Гэвч цаг алга.  
Хурдлахгүй бол.



аааааааа!



Яа яа,  
халуун байна.




Гэрэнд  
нь хийхээ  
мартчихаж

хурдан, хурдан!





дараагийнх  
бахиар....



яааааа

Энэ чинь одоо,  
Ямар гэчийн  
өдөр вэ?





## Багаж ашиглах санамж

### 1 | Гагнуурын багажыг сэгсрэхгүй байх!

NG




OK




Гагнуурын багаж аюултай тул огт сэгсэрч болохгүй.

### 2 | Багажыг зөв байрлуулах!

NG



OK



Гагнуурын багажыг зориулалтын гэрэнд байрлуулж, үзүүрийг өөрлүүгээ чиглүүлэхгүй байрлуулах.


Багажыг хэрэглэхдээ анхааралтай байгаарай!





Тохиолдол 6

Төмөр хавтан зөөвөрлөх үеийн осол



За

カチカチ

Төмөр хавтан хүнд ч гэсэн,

би биеийн хүчний ажлыг бол чадна шүү

ウソ



Уйлдвэр рүү зөөгөөд

ガラガラ



буулгаад.....



たが たが

баларсан юм бэ!

яааа!



Хөөе яасан? Гэмтчихсэн үү?

Мөрөө цохьчихлоо. Төмөр хавтан нураад...

Гэхдээ зүгээрээ









Босоогоор нь зөөхөөр тэгнэ ш дээ.


Нурах аюултай зүйлийг хөндлөнгөөр нь тавих ёстой.

За, ойлголоо.











## Төмөр хавтанг зөөвөрлөх санамж

**1** | Хамгаалах хэрэгсэлийг дүрмийн дагуу өмсөөрэй!



Бээлий болон аюулгүй гутлыг дүрмийн дагуу өмсөх

**2** | Ажлын хувцасны ханцуйг шамлахгүй байх!



Ажлын үеэр ханцуй шамлахгүй, дүрмийн дагуу зөв өмсөөрэй.

**3** | Төмөр хавтанг босоогоор нь тавихгүй байх!



Төмөр хавтанг босоогоор нь хураавал нурах аюултай тул хөндлөнгөөр нь хэвтүүлж тавиарай.





Хүнд, их хэмжээний зүйлстэй харьцахдаа анхааралтай байгаарай!









Тохиолдол 7

Гагнуурын ажлаас үүдэн гарах түлэгдэлт болон гал












Юугаа хийгээд байгаан бэ?

Уучлаарай



Галыг тэр дор нь унтраасан болохоор түлэгдэлт бага байна.

Анхааралтай байцгаая.

Галыг унтраалгүй оройтсон бол түймэр ч гарах аюултай байлаа.




Дүрэм журмаа дагахгүй, гэмтчихвэл найзууд, гэр бүлийнхэн чинь санаа зовно.

Ажиллаж чадахгүй болчих юм бол орлого ч үгүй чи өөрөө л хүнд байдалд орно ш дээ.

## Гагнуур хийх санамж

### 1 | Гагнуур хийж дуусангуутаа шууд барихыг хориглоно!




Гагнуур хийсний дараа төмөр хавтан зэрэг төмөр зүйлсийг шууд бариж авч болохгүй.

### 2 | Ажил эхлэхээсээ өмнө эргэн тойрноо сайн шалгацгаая!



Гагнуурын ажил эхлэхээс өмнө эргэн тойрондоо шатах зүйл байгаа эсэхийг шалгаарай.



Гагнуур хийх үед түлэгдэх болон гал гарах аюултай тул анхааралтай байцгаая!








# Тохиолдол 8

## Техник төхөөрөмжинд асуудал гарсан үеийн осол



### Хэдэн минутын дараа







Халцгай халцгай!!



Хөөе, Яаваа?



Боолт гагнаж байтал...



Хөөе, Яасан бэ?

Уу, уучилаарай.




Бэртчихсэн байна ш дээ. Хурдан эмнэлгийн тусламж авахгүй бол!

Яана аа





Энэ удаа юу вэ?




Энэ!! боолт нь зөрчихөж.

Гараараа янзлахгүй бол болохгүй нь дээ.





Дараагийн өдөр нь



## Механик ажлын үед ямар нэгэн гэмтэл гарсан тохиолдолд анхаарах зүйл

### 1 | Ганцаараа шийдэх гэлгүй шууд мэдээллээрэй!


Механик ажлын үед гэмтэл гарвал ганцаараа шийдэлгүй шууд хариуцаж байгаа хянагчид хэлээрэй.




### 2 | Механик ажлын үед асуудал үүсвэл шууд унтраагаарай!




Механик ажлын үед гэмтэл гарсан тохиолдолд шууд зогсоо! дууд! хүлээ!







Аюул сансанаас чинь илүү ойрхон байгааг сайн мэдэж авсан уу?



Тэмдэгт дээрх хүн хэн нэгэнтэй адилхан биш байна уу?

Айн? Ямар нэгэн юм хэлсэн үү?



Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг дор бүрнээ санаж, дүрмийг сахих нь чухал юм.

Тэгээд



Ажлын байрны осол бол өрөөл бусдын бус бидний асуудал.

Дүрэм журамаа дагаж мөрдөнө гэдэг нь "бие", "гэр бүл", "амьдрал" -аа хамгаалж байгаа гэсэн үг. Сайн санаж яваарай!



Ямар нэгэн зүйл болсон тохиолдолд

ажлын байран дээрх харилцан яриа нь маш чухал.



За

Осол гэмтлээс болгоомжилж өдөр бүр хичээж ажиллацгаая.



Үүнээс болгоомжилцгооё.

**Аюулгүй байдал/Эрүүл мэндийн төлөөх санамж**

**Дүрэм журмаа сайн мөрдөж,  
ослоос өөрсдийгөө хамгаалцгаая!**



**1 | Эмх цэгцгүй хувцаслахаас болгоомжил!**



Ханцуйгаа шамлах, гоёл чимэглэлээ авахгүйгээр ажиллах нь аюултай тул анхаарна уу



Урт үс ямар нэгэн зүйлтэй орооцолдох аюултай тул дээш нь шууж малгайн дотроо хийцгээе.

**2 | Хамгаалах хэрэгсэлийг дүрмийн дагуу хэрэглэцгээе!**



Хайнга хандахгүйгээр дүрмийн дагуу зөв зүүсэн эсэхээ шалгаарай.



Хэрэв эвдэрсэн, гажсан, бохирдсон байвал шинээр солиорой.

**3 | Ажлын горимыг дагаж мөрдөцгөөе!**



Ажлаа дүрмийн дагуу гүйцэтгээрэй. Үүнийг өөрчлөх эсвэл тэр чигээр нь орхиж болохгүй.




Ажлын байр болон гарцыг цэгцтэй цэвэр байлгаж 4S (нийтлэг сургалтийн материалыг үзнэ үү)-г санаж явцгаая.

**4 | Болгоомжгүй үйлдлээс зайлс хийнэ үү!**



Алхангаа гар утас ашиглахгүй байна уу!



Краны өргөсөн ачааны ойролцоо явахгүй байна уу!





## Зурагт номоор ойлгох аж үйлдвэрийн 3-н салбарын эрүүл ахуй, аюулгүй байдал

2020 он 3 сар хэвлэл

Хэвлэл: Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын яам

Төлөвлөлт: Мизүхо мэдээлэл судалгааны хүрээлэн ХХК

Хяналт: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын  
материал бэлтгэх хороо

Үйлдвэрлэлийн 3-н салбарт аюулгүй ажиллагааны

боловсролын материал бий болгох ажил

Бүтээгч: Sideranch ХХК

Энэ бичиг баримттай холбоотой лавлагаа авах  
Эрүүл мэнд, Хөдөлмөр, халамжийн яамны Хөдөлмөрийн  
стандартын товчоо Эрүүл ахуй, аюулгүй байдлын хэлтсийн  
аюулгүй ажиллагааны хэсэг